



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/72/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор:	Ц.Наранчимэг
	Утас: 261665	Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:	Э.Энхбаатар
	Утас: 260512	Цахим хаяг: <a href="mailto:enkhbaatare@audit.gov.mn">enkhbaatare@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор:	О.Баярмаа
	Утас: 261628	Цахим хаяг: <a href="mailto:bayarmaao@audit.gov.mn">bayarmaao@audit.gov.mn</a>
	Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн Захирал:	О.Бурмаа
	Утас: 99168735	Цахим хаяг: <a href="mailto:aetb.audit@gmail.com">aetb.audit@gmail.com</a>
Аудитор:	Д.Даваасүрэн	
Утас: 99092231	Цахим хаяг: <a href="mailto:aetb.audit@gmail.com">aetb.audit@gmail.com</a>	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт .....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	11
4.1 Ерөнхий зүйл .....	11
4.2 Материаллаг байдал.....	11
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	13
5.1 Төлбөрийн акт .....	13
5.2 Албан шаардлага .....	13
5.3 Хариуцлага тооцуулах албан шаардлага .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УАӨСХАТ	Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв
УАГ	Үндэсний аудитын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХКОМ	Хамтарсан Кредит олгох Механизм



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН  
СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ  
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАТЧИМЭГ  
ТАНАА

2026.03.13 № 06/644  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалтай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тосцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тус төвийн захирал 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 12 дугаар 31-нийг хүртэлх хугацаанд байгууллагын харилцах данснаас нийт 539.6 сая төгрөгийн зарлагын 50 удаагийн гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүй, ямар нэг хяналтгүй хийж гүйцэтгэсэн;
- Авлагын дансанд бүртгэлтэй 153.7 сая төгрөгийн авлага, 531.6 төгрөгийн төгрөгийн өр төлбөрийн тооцоог нийлж баталгаажуулаагүй;
- Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нэг иргэний ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 27.9 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй;
- Ажилд эгүүлэн тогтоолгох, нөхөн олговор олгох маргаантай шүүх хуралд ажил олгогчийн өмнөөс өмгөөлөгчөөр оролцох зардалд 29.0 сая төгрөг, байгууллагын дүрэм, журмыг шинэчлэхтэй холбоотой зардалд 37.5 сая төгрөг, бусад гэрээт ажлын

зардалд 111.3 сая төгрөг, нийт 177.8 сая төгрөгийг ажлын даалгавар, харьцуулалтын судалгаагүй, ирүүлсэн үнийн саналгүй, гэрээ дүгнэсэн актгүй, шууд гэрээ байгуулж, төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан;

- Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн зэрэг 4 алба хаагчийн гадаад томилолтын зардалд анхан шатны баримтын бүрдэлгүй 24.2 сая төгрөгийг зарцуулсан;

Эдгээр зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.2.4, 20.2.5, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 7, 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 8, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 2025/16 дугаартай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 3.2.1 гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Толилуулга ба тодруулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолоор Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-т нэгтгэх шийдвэр гарч, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны А/56 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 858 дугаар тогтоолоор Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 99 нэрийн 5,108.1 сая төгрөгийн хөрөнгийг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ балансаас баланст шилжүүлэн авсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ 2025 оны эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 1,434.4 сая төгрөг буюу 35.0 хувиар тасалсан байна.

### **Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,585,754,596.94	538,139,823.89
1.1.02	Дансны авлага	45,596,647.95	66,881,929.95
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	3,236,650.82
1.1.06	Бараа материал	53,132,070.00	156,043,474.00
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	32,675,010.00	83,610,000.00
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	75,997,800.00	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,793,156,124.89</b>	<b>847,911,878.66</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	73,779,835.07	4,495,189,548.11
1.2.02	Биет бус хөрөнгө	-	-
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>73,779,835.07</b>	<b>4,495,189,548.11</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,866,935,959.96</b>	<b>5,343,101,426.77</b>
2.1.1.1	Дансны өглөг	1,951,412.98	-
2.1.1.2	Цалингийн өглөг	55,755,000.00	55,755,000.00
2.1.1.3	Татварын өр	4,847,441.78	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,461,183,223.64	475,826,312.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,523,737,078.40</b>	<b>531,581,312.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,523,737,078.40</b>	<b>531,581,312.00</b>
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	9,220,000.00	24,920,000.00
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	-	4,473,507,664.89
<b>2.3.09</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>333,978,881.56</b>	<b>313,092,449.88</b>
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	46,296,698.03	2,261,918.32
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	287,682,183.53	310,830,531.56
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>343,198,881.56</b>	<b>4,811,520,114.77</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,866,935,959.96</b>	<b>5,343,101,426.77</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	3,083,731,404.69	2,610,722,899.30
02	Борлуулалтын өртөг	2,849,736,432.98	2,397,826,624.63
<b>03</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>233,994,971.71</b>	<b>212,896,274.67</b>
05	Хүүний орлого	8,002,381.78	16,573,510.12
08	Бусад орлого	10,549,486.72	2,740,380.00
<b>08.1</b>	<b>Орлогын дүн</b>	<b>18,551,868.50</b>	<b>19,313,890.12</b>
09	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	198,450,000.00	235,120,133.78
<b>12.1</b>	<b>Зардлын дүн</b>	<b>198,450,000.00</b>	<b>235,120,133.78</b>
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	3,584,118.32	29,073,661.57
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(6,240,182.95)	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	(23,650,450.00)
<b>17.1</b>	<b>Олз, гарзын дүн</b>	<b>(2,656,064.63)</b>	<b>5,423,211.57</b>
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>51,440,775.58</b>	<b>2,513,242.58</b>
19	Орлогын татварын зардал	5,144,077.56	251,324.26
20	Татварын дараах ашиг (алдагдал)	46,296,698.02	2,261,918.32
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	46,296,698.02	2,261,918.32
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>46,296,698.02</b>	<b>2,261,918.32</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,904,273,408.10</b>	<b>1,646,883,049.90</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,337,158,853.39	1,624,420,927.66
1.1.6	Бусад мөнгөн орлого	567,114,554.71	22,462,122.24
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,703,841,512.88</b>	<b>2,630,208,644.64</b>
1.2.1	Ажилчдад төлсөн	445,175,725.48	556,328,956.95
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	147,188,886.46	163,654,282.54
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	10,529,199.00	42,148,500.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	6,150,000.00	32,308,350.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	69,985,996.93	68,148,982.64
1.2.9	Бусад мөнгөн зарлага	3,024,811,705.01	1,767,619,572.51
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>1,200,431,895.22</b>	<b>(983,325,594.74)</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>8,002,381.78</b>	<b>16,573,510.12</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	8,002,381.78	16,573,510.12
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>26,449,800.00</b>	<b>86,788,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	26,449,800.00	86,788,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(18,447,418.22)</b>	<b>(70,214,489.88)</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>9,065,984.03</b>	<b>30,213,434.12</b>
3.1.4	Бусад	9,065,984.03	30,213,434.12
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>29,651,265.71</b>	<b>24,288,122.55</b>
3.2.4	Төлсөн ногдол ашиг	24,169,400.00	23,148,350.00
3.2.5	Бусад	5,481,865.71	1,139,772.55
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(20,585,281.68)</b>	<b>5,925,311.57</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,161,399,195.32</b>	<b>(1,047,614,773.05)</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	424,355,401.62	1,585,754,596.94
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,585,754,596.94	538,139,823.89

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрв.нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	<b>2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	-	-	-	-	-	<b>311,851,583.53</b>	<b>311,851,583.53</b>
03	<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	-	-	-	<b>311,851,583.53</b>	<b>311,851,583.53</b>
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	46,296,698.03	46,296,698.03
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	24,169,400.00	<b>24,169,400.00</b>
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	9,220,000.00	-	-	-	9,220,000.00
09	<b>2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	-	-	<b>9,220,000.00</b>	-	-	<b>333,978,881.56</b>	<b>343,198,881.56</b>
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	<b>9,220,000.00</b>	-	-	<b>333,978,881.56</b>	<b>343,198,881.56</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	2,261,918.32	<b>2,261,918.32</b>
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	4,473,507,664.89	-	<b>4,473,507,664.89</b>
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	23,148,350.00	<b>23,148,350.00</b>
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	15,700,000.00	-	-	-	<b>15,700,000.00</b>
17	<b>2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	-	-	<b>24,920,000.00</b>	-	<b>4,473,507,664.89</b>	<b>313,092,449.88</b>	<b>4,811,520,114.77</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэт	Хувь
A	1	3	4	5	6=5-3	7=5/3%	8=5-4	9=5/4%
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>		<b>2,360,784.4</b>	<b>4,094,616.8</b>	<b>2,660,250.2</b>	<b>299,465.8</b>	<b>112.7</b>	<b>(1,434,366.6)</b>	<b>65.0</b>
1	НҮБУАӨСК-н хэрэгжилтийг хангах Үндэсний тавдугаар тайлан илтгэл, хоёр жил тутмын ил тод байдлын тайлан боловсруулах төсөл /NC5/BTR1,2	674,000.0	1,245,386.0	923,696.4	249,696.4	137.0	(321,689.6)	74.2
	ХКОМ-ын нарийн бичгийн газрын санхүүжилт	63,754.6	60,000.0	31,775.2	(31,979.5)	49.8	(28,224.9)	53.0
	Монголын хүлэрт газрыг удирдах, бэлчээрийн экосистем, нүүдэлчин малчдын амьжиргааг дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх төсөл	674,000.0	2,323,430.8	648,754.5	(25,245.5)	96.3	(1,674,676.3)	27.9
	Чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлэх дэд төслүүд	949,029.8	465,800.0	1,056,024.2	106,994.4	111.3	590,224.2	226.7
2	<b>Нийт орлого</b>	<b>3,868,619.4</b>	<b>4,094,616.8</b>	<b>2,660,250.2</b>	<b>(1,208,369.2)</b>	<b>68.8</b>	<b>(1,434,366.6)</b>	<b>65.0</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>3,833,432.0</b>	<b>3,953,059.1</b>	<b>2,657,737.0</b>	<b>(1,175,695.0)</b>	<b>69.3</b>	<b>(1,295,322.1)</b>	<b>67.2</b>
	<b>Үүнээс: Удирдлагын зардал</b>	<b>138,262.0</b>	<b>208,392.0</b>	<b>235,120.1</b>	<b>96,858.1</b>	<b>170.1</b>	<b>26,728.1</b>	<b>112.8</b>
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>35,187.4</b>	<b>141,557.7</b>	<b>2,513.2</b>	<b>(32,674.2)</b>	<b>7.1</b>	<b>(139,044.5)</b>	<b>1.8</b>
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>31,668.7</b>	<b>127,401.9</b>	<b>2,261.9</b>	<b>(29,406.8)</b>	<b>7.1</b>	<b>(125,140.0)</b>	<b>1.8</b>
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>253,276.0</b>	<b>327,871.4</b>	<b>226,154.6</b>	<b>(27,121.4)</b>	<b>89.3</b>	<b>(101,716.8)</b>	<b>69.0</b>
	а/ Орлогын татварт	3,518.7	14,155.8	251.3	(3,267.4)	7.1	(13,904.4)	1.8
	в/ НДШ	182,471.0	228,503.0	163,654.3	(18,816.7)	89.7	(64,848.8)	71.6
	г/ Хүн амын орлогын татвар	67,286.2	85,212.6	62,249.0	(5,037.2)	92.5	(22,963.6)	73.1
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	24,169.4	9,500.6	23,148.4	(1,021.1)	95.8	13,647.8	243.7
8	Нийт ажиллагсдын тоо	20.0	29.0	24.0	4.0	120.0	(5.0)	82.8
9	Нийт цалингийн сан	653,202.0	952,096.0	695,125.0	41,923.0	106.4	(256,971.0)	73.0
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	2,721.2	2,735.9	2,413.6	(307.5)	88.7	(322.3)	88.2
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	1.0	1.0	1.0	-	100.0	-	100.0
12	Хөрөнгө оруулалт	53,140.0	276,335.0	88,888.0	35,748.0	167.3	(187,447.0)	32.2
13	<b>Нийт авлага</b>	<b>65,000.0</b>	<b>50,000.0</b>	<b>70,118.6</b>	<b>5,118.6</b>	<b>107.9</b>	<b>20,118.6</b>	<b>140.2</b>
14	<b>Нийт өглөг</b>	<b>38,000.0</b>	<b>50,000.0</b>	<b>55,755.0</b>	<b>55,755.0</b>	<b>146.7</b>	<b>5,755.0</b>	<b>111.5</b>

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ нь уур амьсгалын нөхцөл байдал, өөрчлөлтийн чиглэлээр эдийн засаг, нийгмийн салбар дамнасан олон улсын дэмжлэг, санхүүжилт бүхий төсөл, хөтөлбөр боловсруулах, уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд холбогдох тайлан илтгэл гаргах, тэдгээртэй холбоо бүхий бусад үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд зангидан зохицуулах, Уур амьсгалын ногоон сан зэрэг уур амьсгалын санхүүжилтийн олон улсын байгууллагатай ажиллах мэргэжлийн албаны үүрэг гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлдэг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант онд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ нь 3 зорилгын хүрээнд нийт 7 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

1. Байгууллагын хэвийн ажиллагааг хэвийн найдвартай ажиллагааг хангах
  - Захиргаа, удирдлагаар хангаж, хүний нөөцийг хөгжүүлэх;
  - Хамтын ажиллагааг хөгжүүлэх;
  - Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах;
2. Судалгаа, шинжилгээний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
  - Уур амьсгалын өөрчлөлтийн талаар гаргасан төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд өөрийн байгууллагын зүгээс шаардлагатай судалгаа, шинжилгээний төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
  - Хамтын ажиллагааг хөгжүүлэх;
  - Систем, сүлжээний хэвийн ажиллагааг хангах;
3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах
  - Хууль, тогтоомж, гэрээ хэлцлийн биелэлтэд хяналт тавих;

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус төв нь үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгавар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж үнэллээ.

Тайлант онд төслийн баримт бичигт заасан үйл ажиллагааны хүрээнд баталсан санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, тайланг зардлын ангиллаар гаргаж, улирал тутам донор болох санхүүжүүлэгч талд тайлагнадаг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн

тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын 2022 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг ашиглаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,476.2 сая төгрөгөөр буюу 186.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,585.8	538.1	(1,047.6)
Авлага	45.6	70.1	24.5
Бараа материал	53.1	156.0	102.9
Урьдчилж төлсөн зардал	32.7	83.6	50.9
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	76.0	-	(76.0)
Үндсэн хөрөнгө	73.8	4,495.2	4,421.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,866.9</b>	<b>5,343.1</b>	<b>3,476.2</b>
Өр төлбөр	1,523.7	531.6	(992.2)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	343.2	4,811.5	4,468.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,866.9</b>	<b>5,343.1</b>	<b>3,476.2</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 538.1 сая төгрөг болж 1,047.6 сая төгрөгөөр буурсан нь тус төвд хэрэгжиж байгаа 2 хөтөлбөр, төслийн санхүүжилт тайлант онд бүрэн ороогүйгээс шалтгаалсан;

Авлага дансны үлдэгдэл 70.1 сая төгрөг болж 24.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан хөрөнгийг хүлээж аваагүй авлагаар бүртгэсэн, Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан 1 иргэний ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-ийн 20.1 сая төгрөгийг Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт давхар төлсөн зэрэгтэй холбоотой;

Бараа материалын дансны үлдэгдэл 156.0 сая төгрөг болж, 102.9 сая төгрөгөөр өсөхөд тус төвд Монгол-Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ыг нэгтгэж 113.8 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь нөлөөлжээ;

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 83.6 сая төгрөг болж, 50.9 сая төгрөгөөр өссөн нь 3 байгууллагад гэрээт ажлын урьдчилгаа төлбөрт 53.6 сая төгрөгийг төлсөнтэй холбоотой;

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг) хөрөнгө дансны үлдэгдэл 76.0 сая төгрөгөөр буурсан нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын А/325 тушаалаар Байгаль орчны судалгаа, шинжилгээний төв УТҮГ-т 76.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлснээс шалтгаалсан;

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,495.2 сая төгрөг болж 4,421.4 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна.

- Тайлант онд 88.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 858 тогтоолоор Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 99 нэрийн 5,108.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 531.6 сая төгрөг болж 992.2 сая төгрөгөөр буурсан нь Нэгдсэн үндэсний байгууллагын Байгаль орчны хөтөлбөрийн ажлын тайлан дүгнэгдсэнээр өр төлбөрийг бууруулж тайланг хүргүүлснээр өр төлбөр дансны бүртгэл буурдагтай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 4,468.3 сая төгрөгөөр өсөхөд Засгийн газрын 2025 оны 61 дүгээр тогтоолоор Монгол-Кувейтийн байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын хөрөнгө, бараа материалыг хүлээн авч санхүүгийн тайланд нэгтгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

**Биет бус хөрөнгө:** Тус төвийн биет бус хөрөнгийн дансанд 10.9 сая төгрөгийн өртөгтэй санхүүгийн 3 программ хангамж бүртгэлтэй ба тайлант онд программ хангамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр, лицензийн төлбөрт 13.5 сая төгрөгийг төлсөн байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө/техник, эдийн засгийн үзүүлэлт/зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 733 дугаар тогтоолоор тус төвийн “2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 4,094.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 3,953.1 сая төгрөгөөр, 127.4 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 276.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,660.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,657.7 сая төгрөгийн зардал гарган, 2.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 2,660.3 сая төгрөг болж төлөвлөснөөс 1,434.4 сая төгрөг буюу 35.0 хувиар, нийт зардлын гүйцэтгэл 2,657.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,295.3 сая төгрөг буюу 32.8 хувиар тус тус дутуу гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хөрөнгө худалдан авахад өөрийн эх үүсвэрээс 88.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант оны татварын өмнөх ашиг 2.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 139.0 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 312 тогтоолын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашигт 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс 23.1 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Тайлант онд тус төв нь сургалтад 471.0 сая төгрөгийг, хурал зөвлөгөөний арга хэмжээнд 184.0 сая төгрөгийг, томилолтын зардалд 212.0 сая төгрөгийн томилолтын зардал гаргаж үүнээс гадаад томилолтын 4 арга хэмжээнд 6 хүнийг хамруулж нийт 69.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

#### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын 2025 оны А/1 дүгээр тушаалаар 40 бараа, ажил, үйлчилгээний 1,090.6 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 382.4 сая төгрөгийн худалдан авалтыг тайлагнасан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төвийн үйл ажиллагааг сайжруулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, үүссэн авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хийх, татварын цахим төлбөрийн системд и-баримтыг бүртгэж хэвших зөвлөмжүүдийг өглөө.

Аудитыг “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн, аудиторын туслах Б.Мөнгөнцэцэг нар гүйцэтгэж, ахлах аудитор О.Чулуунбаатар, захирал О.Бурмаа нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа, аудитын менежер Э.Энхбаатар, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж ажиллав.

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 3,041.9 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 30.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 6.4 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгөв.

**Илрүүлэлт:** Тайлант онд хүнс, чихэр, хоол, жимс, печень зэргийг 6.4 сая төгрөгөөр худалдан авч төсвийг үр ашиггүй хэмнэлттэй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэж тус тус заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж төсвийг үр ашиггүй хэмнэлттэй зарцуулахгүй ажиллах зөвлөмж өгөв.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 6.4 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөв.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

САГ-2026/72/НА-СТА-ТӨА

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

**Илрүүлэлт:** Шилэн дансны цахим системд Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, дараа жилийн зорилтот түвшин, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаанд нь мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор"; 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор"; 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор;" гэж тус тус заасантай нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмж өгөв.

Иймд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг завсрын аудитад хамруулж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт авч, эрсдэлийг тодорхойлж аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 93.6 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага хүргүүлснээс, хэрэгжилт 33.3 хувийн биелэлттэй байна.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	17.6	-	-	-
Албан шаардлага	2	76.0	1	76.0	50.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>93.6</b>	<b>1</b>	<b>76.0</b>	<b>33.3</b>

Өмнөх аудитаар суутган тооцож тайлагнаагүй 17.6 сая төгрөгийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг, зорилтот түвшний төлөвлөгөөг тасалсан зөрчлийг зогсоох албан шаардлагыг тус тус хэрэгжүүлээгүй тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзсэн.

- Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-т хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн гэрээний хугацаа 2026 онд дуусах тул санхүүжилт, түүний хэрэгжилтийг бүрэн үнэлсэн эсэхийг шалгах.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой илэрсэн нийт 101.7 сая төгрөгийн 2 алдааг<sup>1</sup> арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### Залруулаагүй алдаа:

- Ажлаас үндэслэлгүй халагдсан гэх шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, маргаантай 4 иргэнд нийт 55.8 сая төгрөгийн цалингийн өглөгийг хувь хүний нэр дээр үүсгэсэн нь НББОУС 1-д “Санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, товч тодорхой байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулах зөвлөмж өгөв.
- Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан 2 иргэнд олгосон ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-д төлсөн нийт 45.9 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх авлага үүсгээгүй зардлаар бүртгэсэн нь НББОУС 1-д “Санхүүгийн тайланд тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, товч тодорхой байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 3,172.9 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 24.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1,157.0 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага, 1,991.7 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага өгч, үүнээс хууль хяналтын байгууллагад 539,6 сая төгрөгийг шилжүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,172.9 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 3,146.6 сая төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тус төвийн захирлын 2025 оны А/35 дугаар тушаалаар БОУАӨЯ-ны газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн 4 алба хаагчид гадаад томилолтын зардал 24.2 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд анхан шатны баримтын бүрдэлгүй, томилолтын тайлан, илтгэх хуудасгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”, Төрийн болон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;” гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бусад байгууллагын албан хаагчдад олгосон томилолтын зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх.

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 153.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох.

2. Тайлант оны эцэст өр төлбөр дансанд бүртгэлтэй 531.6 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах.

3. Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нэг иргэний ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-д төлсөн 27.9 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан иргэнд олгосон зардлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй зөрчлийг зөрчлийг арилгах

4. Ажилд эгүүлэн тогтоолгох, нөхөн олговор олгох маргаантай шүүх хуралд ажил олгогчийн өмнөөс өмгөөлөгчөөр оролцох зардалд нийт 29.0 сая төгрөгийг ажлын даалгавар, харьцуулсан үнийн саналгүй шууд гэрээ байгуулж, гэрээ дүгнэсэн актгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, 35 дугаар зүйлийн 35.2-т “Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАҮХТухай хуулийг зөрчмн ажлын даалгавар, харьцуулсан үнийн саналгүй, шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоох.

5. Төвийн захирлын 2025 оны А/18 дугаар тушаалаар байгууллагын дүрэмд дүн шинжилгээ хийж, төсөл боловсруулах 5.0 сая төгрөг, А/27 дугаар тушаалаар цалин хөлсний журам, хөдөлмөрийн сахилга, гомдол гаргах, ажлын эцсийн үр дүн, хүлээх хариуцлага, гэрээг дүгнэх журам, эд хөрөнгийн хохирол нөхөн төлүүлэх журам, ажилтны мэдээллийг авах, боловсруулах хадгалах ашиглах журам боловсруулах 17.5 сая төгрөг, 2025 оны А/98 дугаар тушаалаар Монгол-Кувейт төвийг нэгтгэхтэй холбоотой дүрэм, бүтэц, албан тушаалын жагсаалт, боловсруулах 15.0 сая төгрөг, А/9 дүгээр тушаалаар 19.3 сая төгрөг, А/14 дүгээр тушаалаар 14.8 сая төгрөг, А/15 дугаар тушаалаар 14.0 сая төгрөг, А/16 дугаар тушаалаар 15.6 сая төгрөг,

A/54 дүгээр тушаалаар 19.7 сая төгрөг, A/57 дугаар тушаалаар 3.8 сая төгрөг, A/91 дүгээр тушаалаар 10.7 сая төгрөг, тушаалгүй 13.5 сая төгрөг, нийт 148.8 сая төгрөгийг ажлын даалгавар, харьцуулалтын судалгаа, ирүүлсэн үнийн саналгүй шууд гэрээ байгуулж төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан, гэрээг дүгнэсэн актгүй, баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.”, 35 дугаар зүйлийн 35.2-т “Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох.

6. Татварын И-баримт цахим системд 266.0 сая төгрөгийн төлбөрийн баримт дутуу бүртгэж, гүйлгээ хийж баталгаажуулсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын И-баримт цахим системд төлбөрийн баримтыг дутуу бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох.

### **5.3 Хариуцлага тооцуулах албан шаардлага**

#### **5.3.1 Зардал болон өмнөх аудитын зөвлөмжийн биелэлттэй холбоотой.**

##### Илрүүлэлт:

1. Тус төвийн захирал 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 12 дугаар 31-нийг хүртэлх хугацаанд байгууллагын харилцах данснаас нийт 539,642,429.40 /таван зуун гучин есөн сая зургаан зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун хорин есөн төгрөг дөчин мөнгө/-ийн зарлагын тавин удаагийн гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүй, ямар нэг хяналтгүй хийж гүйцэтгэсэн;
2. Өмнөх аудитын зөвлөмжөөр өгсөн, иргэнээс суутган тооцож тайлагнаагүй 17,645,722.32 /арван долоон сая зургаан зуун дөчин таван мянга долоон зуун хорин хоёр мянган төгрөг гучин хоёр мөнгө/-ийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй;
3. Тайлант онд эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 1,434,366,580.00 /нэг тэрбум дөрвөн зуун гучин дөрвөн сая гурван зуун жаран зургаан мянга таван наян төгрөг/ буюу 35.0 хувиар тасалсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийг хуулийн хугацаанд аудитад санхүүгийн тайлангийн хамт ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай САГ-2026/72/НА-СТА-ТӨА

хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, 7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;”, 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 8-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 2025/16 дугаартай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 3.2.1-д "Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын харилцах данснаас зарлагын гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүй, хяналтгүй хийсэн, өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй буруутай албан тушаалтанд хуулийн заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Ажлаас үндэслэлгүй халагдсан гэх шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй, маргаантай 4 иргэнд нийт 55,755.0 мянган төгрөгийн цалингийн өглөгийг хувь хүний нэр дээр үүсгэсэн байна.	1	55.8	-	-	-	-	-	-	1	55.8	1	55.8
2	Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан 2 иргэний ажилгүй байсан хугацааны цалин, НДШимтгэлд төлсөн нийт 45,946.3 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх авлага үүсгээгүй зардлаар бүртгэсэн байна.	1	45.9	-	-	-	-	-	-	1	45.9	1	45.9
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>101.7</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>101.7</b>	<b>2</b>	<b>101.7</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Тус төвийн захирал 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 12 дугаар 31-нийг хүртэлх хугацаанд байгууллагын харилцах данснаас нийт 539.6 төгрөгийн зарлагын тавин удаагийн гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүй, ямар нэг хяналтгүй хийж гүйцэтгэсэн; 2. Өмнөх аудитаар тогтоосон иргэнээс суутган тооцож тайлагнаагүй 17.6 сая төгрөгийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй; 3. Тайлант онд эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 1,434.4 сая төгрөгөөр буюу 35.0 хувиар тасалсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийг аудитад санхүүгийн тайлангийн хамт ирүүлээгүй байна.	1	1,991.7	-	-	-	-	1	1,991.7	1	539.6
Тайлант оны эцэст өглөгийн дансанд бүртгэлтэй 531.6 төгрөгийн өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.	1	531.6	-	-	1	531.6	-	-	-	-
Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 153.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	1	153.7	-	-	1	153.7	-	-	-	-
Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан 1 иргэнд ажилгүй байсан хугацааны цалин, НДШ-д төлсөн 27.9 төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.	1	27.9	-	-	1	27.9	-	-	-	-
Ажилд эгүүлэн тогтоолгох, нөхөн олговор олгох маргаантай шүүх хуралд ажил олгогчийн өмнөөс өмгөөлөгчөөр оролцох зардалд нийт 29.0 сая төгрөгийг шууд гэрээ байгуулан ажлын даалгавар, харьцуулсан үнийн саналгүй, шууд гэрээ байгуулж, гэрээ дүгнэсэн актгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд: 1. Төвийн захирлын 2025 оны	1	29.0	-	-	1	29.0	-	-	-	-

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

A/53 тушаалаар 19.0 төгрөгийн Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа үзүүлэх 2 гэрээ байгуулж, урьдчилгаанд 10.0 сая төгрөгийг; 2. A/99 тушаалаар төвийн эрх ашгийг хамгаалах зорилгоор шүүхэд төлөөлөх, эрх зүйн баримт бичиг боловсруулахад сар бүр 5.0 сая төгрөгийг; 3.Гэрээ 24/111 -гээр шүүхэд төлөөлөх өмгөөлөгчийн зардалд 14.0 сая төгрөгийг.										
Төвийн захирлын 2025 оны A/35 тушаалаар Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн 4 алба хаагчийн гадаад томилолтын зардалд нийт 24.2 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд анхан шатны баримт бүрдэлгүй, томилолтын тайлангүй байна.	1	24.2	1	24.2	-	-	-	-	-	-
Төвийн захирлын 2025 оны A/18 тушаалаар байгууллагын дүрэмд дүн шинжилгээ хийж, төсөл боловсруулах 5.0 сая төгрөг, 2025 оны A/27 тушаалаар цалин хөлсний журам, хөдөлмөрийн сахилга, гомдол гаргах, ажлын эцсийн үр дүн, хүлээх хариуцлага, гэрээг дүгнэх журам, эд хөрөнгийн хохирол нөхөн төлүүлэх журам, ажилтны мэдээллийг авах, боловсруулах хадгалах ашиглах журам боловсруулах 17.5 сая төгрөг, 2025 оны A/98 тушаалаар Монгол-Кувейт төвийг нэгтгэхтэй холбоотой дүрэм, бүтэц, албан тушаалын жагсаалт, боловсруулах 15.0 сая төгрөг, 2025 оны A/9 тушаалаар 19.3 сая төгрөг, A/14 тушаалаар 14.8 сая төгрөг, A/15 тушаалаар 13.9 сая төгрөг, A/16 тушаалаар 15.6 сая төгрөг, A/54 тушаалаар 19.6 сая төгрөг, A/57 тушаалаар 3.8 сая төгрөг, A/91 тушаалаар 10.7 сая төгрөг, тушаалгүй 13.5 сая төгрөг нийт 148.8 сая төгрөгийг ажлын даалгавар, харьцуулалтын судалгаагүй, ирүүлсэн үнийн саналгүй, гэрээ дүгнэсэн актгүй шууд гэрээ байгуулж, төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	148.8	-	-	1	148.8	-	-	-	-
Татварын И-баримт цахим системд 266.0 сая төгрөгийн төлбөрийн баримт дутуу бүртгэж, гүйлгээ хийж баталгаажуулсан байна.	1	266.0	-	-	1	266.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>3,172.9</b>	<b>1</b>	<b>24.2</b>	<b>6</b>	<b>1,157.0</b>	<b>1</b>	<b>1,991.7</b>	<b>1</b>	<b>539.6</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Шилэн дансны цахим системд Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт, дараа жилийн зорилтот түвшин, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаанд нь мэдээлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Тайлант онд хүнс, чихэр, хоол, жимс, печень зэргийг 6.4 сая төгрөгөөр худалдан авч төсвийг үр ашиггүй хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	6.4	-	-	-	-	1	6.4
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>6.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>6.4</b>
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>6.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>6.4</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 139/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/72/НА - СТА - ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус төвийн даргын 2025 оны А/35 тушаалаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн 4 алба хаагчид гадаад томилолтын зардалд 24,207,920.00 /хорин дөрвөн сая хоёр зуун долоон мянга есөн зуун хорин төгрөг/-ийг зарцуулсан бөгөөд анхан шатны баримтын бүрдэлгүй, томилолтын тайлангүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," Төрийн болон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах," гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бусад байгууллагын алба хаагчдад олгосон томилолтын зардлын 24,207,920.00 /хорин дөрвөн сая хоёр зуун долоон мянга есөн зуун хорин төгрөг/-ийг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирал Б.Батчимэгээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг, Төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны хэлтсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн С.Айтолхын нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 590/A0150079

Улаанбаатар хот

САГ-2026/72/НА-СТА-ТӨА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус төвийн захирал 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2025 оны 12 дугаар 31-нийг хүртэлх хугацаанд байгууллагын харилцах данснаас нийт 539,642,429.40 /таван зуун гучин есөн сая зургаан зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун хорин есөн төгрөг дөчин мөнгө/-ийн зарлагын тавин удаагийн гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүй, ямар нэг хяналтгүй хийж гүйцэтгэсэн;
2. Өмнөх аудитаар тогтоосон иргэнээс суутган тооцож тайлагнаагүй 17,645,722.32 /арван долоон сая зургаан зуун дөчин таван мянга долоон зуун хорин хоёр мянган төгрөг гучин хоёр мөнгө/-ийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй;
3. Тайлант онд эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөөг 1,434,366,580.00 /нэг тэрбум дөрвөн зуун гучин дөрвөн сая гурван зуун жаран зургаан мянга таван наян төгрөг/ буюу 35.0 хувиар тасалсан, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлийг аудитад санхүүгийн тайлангийн хамт ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", 21<sup>1</sup> дүгээр зүйлийн 8-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.1.3-т "аж ахуйн нэгж, байгууллагын

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shoardlaga\2026\0316 SAG-1.Docx

хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 2025/16 дугаартай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 3.2.1-д "Үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийн хүрээнд удирдан зохион байгуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ." гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын харилцах дансны зарлагын гүйлгээг хоёрдугаар гарын үсэггүй, хяналтгүй хийсэн, өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 591/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/72/ИА - СТА - ТӨА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төвийн захирлын 2025 оны А/18 дугаар тушаалаар байгууллагын дүрэмд дүн шинжилгээ хийж, төсөл боловсруулах 5.0 сая төгрөг, А/27 дугаар тушаалаар цалин хөлсний журам, хөдөлмөрийн сахилга, гомдол гаргах, ажлын эцсийн үр дүн, хүлээх хариуцлага, гэрээг дүгнэх журам, эд хөрөнгийн хохирол нөхөн төлүүлдэх журам, ажилтны мэдээллийг авах, боловсруулах хадгалах ашиглах журам боловсруулах 17.5 сая төгрөг, А/9 дүгээр тушаалаар 19.3 сая төгрөг, А/14 дүгээр тушаалаар 14.8 сая төгрөг, А/15 дугаар тушаалаар 13.9 сая төгрөг, А/16 дугаар тушаалаар 15.6 сая төгрөг, А/54 дүгээр тушаалаар 19.6 сая төгрөг, А/57 дугаар тушаалаар 3.8 сая төгрөг, А/91 дүгээр тушаалаар 10.7 сая төгрөг, А/98 дугаар тушаалаар 15.0 сая төгрөг, тушаалгүй 13.5 сая төгрөг, нийт 148.7 сая төгрөгийг ажлын даалгавар, харьцуулалтын судалгаа, ирүүлсэн үнийн саналгүй шууд гэрээ байгуулж төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны тухай хууль зөрчин ажлын даалгавар, харьцуулалтын судалгаа, ирүүлсэн үнийн саналгүй, гэрээ дүгнэсэн актгүй шууд гэрээ байгуулж, төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг, Төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны хэлтсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн С.Айтолхын нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 592/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/72/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст өглөгийн дансанд бүртгэлтэй 531,581,312.00 /таван зуун гучин нэгэн сая таван зуун наян нэгэн мянга гурван зуун арван хоёр төгрөг/-ийн өглөгийн тооцоог нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1--д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг, Төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны хэлтсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн С.Айтолхын нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯАН АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 593/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/72/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст авлагын дансанд бүртгэлтэй 153,728,580.77 /нэг зуун тавин гурван сая долоон хорин найман мянга таван зуун наян мянган төгрөг далан долоон мөнгө/-ийн авлагын тооцоог нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1--д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг, Төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны хэлтсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн С.Айтолхын нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 594/А0150079

Улаанбаатар хот

САГ-2026/72/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан нэг иргэний ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 27,873,617.95 /хорин долоон сая найман зуун далан гурван мянга зургаан зуун арван долоон төгрөг ерөн таван мөнгө/-ийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.", гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсан иргэнд ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн зардлын 27,873,617.95 /хорин долоон сая найман зуун далан гурван мянга зургаан зуун арван долоон төгрөг ерөн таван мөнгө/-ийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР  
О.БУРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 595/А0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/72/НА - СТА - ТӨА

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажилд эгүүлэн тогтоолгох, нөхөн олговор олгох маргаантай шүүх хуралд ажил олгогчийн өмнөөс өмгөөлөгчөөр оролцох зардалд нийт 29,000,000.00 /хорин есөн сая төгрөг/-ийг ажлын даалгавар, харьцуулсан үнийн саналгүй, шууд гэрээ байгуулж, гэрээ дүгнэсэн актгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", 35 дугаар зүйлийн 35.2-т "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ." Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т "Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах;" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тухай хууль зөрчин ажлын даалгавар, харьцуулсан үнийн саналгүй, шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг, Төсөл, хөтөлбөр, хамтын ажиллагааны хэлтсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн С.Айтолхын нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯН АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

ATA16007  
9025037411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-1.Docx



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 596/A0150079

Улаанбаатар хот

САГ - 2026/72/НА - ЦТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Татварын И-баримт цахим системд 265,983,862.38 /хоёр зуун жаран таван сая есөн зуун наян гурван мянга найман зуун жаран хоёр төгрөг гучин найман мөнгө/-ийн төлбөрийн баримтыг дутуу бүртгэж, гүйлгээ хийж баталгаажуулсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж тус тус заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын И-баримт цахим системд төлбөрийн баримт дутуу бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв ТӨААТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг, Төсөл, хөтөлбөр хамтын ажиллагааны хэлтсийн хамтын ажиллагааны мэргэжилтэн С.Айтолхын нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ААВ ЭЭЖИЙН ТЭНГЭРЛЭГ БУЯАН АУДИТ  
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Э.ЭНХБААТАР

О.БУРМАА